



ПРЕМИУМ НЭКСУС ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 5

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг
зарлан хуралдуулах тухай

Премиум Нэксус ХК ("Компани")-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал ("Хурал")-ыг зарлан хуралдуулах асуудлыг хэлэлцээд Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2 дох заалт, 60 дугаар зүйлийн 60.1, 60.2 дох заалт, 62 дугаар зүйлийн 62.1.9, 62.1.14 дэх заалт, 64 дүгээр зүйлийн 64.1, 64.2, 64.4 дэх заалт, Санхүүгийн зохицуулах хорооны Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам болон Компанийн Дүрмийн холбогдох заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хурлыг 2026 оны 04-р сарын 28-ны өдрийн 10:00 цагт Монгол Улс, Улаанбаатар 14241, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпийн гудамж 19А, Шангри-Ла зочид буудал, 1-р давхар, Шанхай өрөөнд биечлэн хуралдуулахаар шийдвэрлэсүгэй.
2. Хурлаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсүгэй. Үүнд:
 - (i) Компанийн 2025 оны жилийн үйл ажиллагааны тайланг танилцуулах;
 - (ii) Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ")-ийн гаргасан дүгнэлтийг батлах;
 - (iii) Компанийн 2025 оны санхүүгийн жилийн цэвэр ашиг (алдагдал)-аас ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн шийдвэр, түүний шалтгааныг танилцуулах.
3. Хурлын зарыг 2026 оны 03-р сарын 18-ны өдөр, давтан зарыг 2026 оны 04-р сарын 01-ний өдөр тус тус өдөр тутмын сонин, Компани болон Монголын Хөрөнгийн Бирж ХК-ийн цахим хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд хүргэсүгэй.
4. Хурлын зар, Хурлаар хэлэлцэх асуудлаар санал өгөх саналын хуудасны загвар, Хурлаас гарах шийдвэр болон Хуралтай холбоотой бусад материалыг тусгасан Хурлын материалыг Нэгдүгээр хавсралтаар баталсугай.
5. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 04-р сарын 01-ний өдрөөр тогтсугай.
6. Хурал хуралдуулахтай холбоотой дор дурдсан баримт бичигтэй танилцах боломжийг 2026 оны 04-р сарын 01-ний өдрөөс хувьцаа эзэмшигчдэд олгосугай. Үүнд:
 - (i) Хурлыг зарлан хуралдуулах тухай ТУЗ-ийн тогтоол;
 - (ii) Хурлын зар;
 - (iii) Хурлаас гарах шийдвэрүүдийн төсөл;
 - (iv) Компанийн 2025 оны жилийн үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлангийн талаарх аудитын байгууллагын дүгнэлт;
 - (v) Хурлын саналын хуудасны загвар.
7. Хурлын даргаар Гүйцэтгэх захирал Г.Чинзоригийг томилсугай.
8. Хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнээр дор дурдсан нэр бүхий ажилтнуудыг томилсугай. Үүнд:

- (i) Д.Бүдханд, Конвиниенс дэлгүүрийн бизнесийн Санхүүгийн газрын захирал (дарга);
 - (ii) М.Отгонтунгалаг, Маркетингийн газрын захирал;
 - (iii) Т.Гантулга, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга.
9. Хурлын Тооллогын комиссын бүрэлдэхүүнээр дор дурдсан нэр бүхий хүмүүсийг томилсугай.
Үүнд:
- (i) Голомт Капитал ҮЦК ХХК-ийн Шинжээч Г.Эрдэнэбаясгалан (дарга);
 - (ii) Голомт Капитал ҮЦК ХХК-ийн Брокер А.Чинзориг;
 - (iii) Голомт Капитал ҮЦК ХХК-ийн Брокер Т.Алтангэрэл.
10. Хурлын материалыг 2026 оны 03-р сарын 18-ны өдөр брокерын компаниуд болох Голомт Капитал ҮЦК ХХК болон Апекс Капитал ҮЦК ХХК-д хүргүүлсүгэй.
11. Хурлын бэлтгэл ажлыг хангах, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах, энэ тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллахад шаардлагатай бүхий л арга хэмжээг авч ажиллахыг Хурал зохион байгуулах комисст үүрэг болгосугай.
12. Хурлын мэдэгдлийг 2026 оны 03-р сарын 16-ны өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн бирж ТӨХК-д хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал (Г.Чинзориг)-д үүрэг болгосугай.

(Гарын үсгийн хуудас дагалдана.)

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ДАРГА (ХАРААТ БУС):



ГАРИ БИОНДО

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД:

А.ГАНХУЯГ

А.ГАНБОЛД

Г.БАТ-ЭРДЭНЭ

Ч.МӨНХЧИМЭГ

Г.ЧИНЗОРИГ

Б.БАТ-ЭРДЭНЭ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮД:

Ө.ЭРДЭНЭЧИМЭГ

В.ГАНЗОРИГ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН МАТЕРИАЛ

Хэрэв та Премиум Нэксус ХК ("Компани") дах бүх хувьцаагаа худалдсан буюу шилжүүлсэн бол энэхүү хурлын материалыг худалдан авагч, шилжүүлэн авагчид эсвэл холбогдох брокерт нь хүлээлгэн өгнө үү.

Хэрэв танд энэхүү хурлын материалын талаар эсвэл хэрхэн хуралд оролцож санал өгөх талаар нэмэлт мэдээлэл шаардлагатай бол өөрийн брокерт эсвэл 8610-6181, gantulga.t@cumongol.mn-д хандан мэдээлэл авна уу.

Хэрэв танд хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, санал өгөх эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан нэмэлт тайлбар шаардлагатай бол Голомт Капитал ҮЦК ХХК-ийн 8527-2507 утсаар мэдээлэл авна уу.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчид 2026 оны 04-р сарын 01-ний өдрөөс 04-р сарын 27-ны өдрийн (ажлын өдрүүдэд) 16:00–18:00 цагийн хооронд Монгол Улс, Улаанбаатар 13312, Баянзүрх дүүрэг, 26-р хороо, Олимп хороолол, Их Монгол улсын гудамж 202, Сакура Тауэр, 7-н давхарт хүрэлцэн ирж хурлыг зарлан хуралдуулах тухай Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ")-ийн 2026 оны 03-р сарын 13-ны өдрийн 5 тоот тогтоол, хурлын зар, хурлын саналын хуудас, хурлаас гарах шийдвэрийн төсөл болон бусад холбогдох материалтай танилцах боломжтой.



ПРЕМИУМ НЭКСУС ХК
(Хувьцааны код: CUMN)

КОМПАНИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ДҮГНЭЛТИЙГ БАТЛАХ ТУХАЙ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдөр нь 2026 оны 04-р сарын 01-ний өдөр байна.

Хурлын санал хураалтыг санал хураалтын хуудасаар урьдчилан болон хурлын үеэр хүлээн авна. Хувьцаа эзэмшигч өөр хүнээр төлөөлүүлэн санал өгөх бол тухайн төлөөлөх хүнд итгэмжлэл олгож нотариатаар баталгаажуулсан байх ба уг итгэмжлэл нь зөвхөн тухайн хурлын санал хураалтад хүчинтэй байна.

АГУУЛГА

	Хуудас
1. Танилцуулга	3
2. Компанийн 2025 оны жилийн үйл ажиллагааны тайлан, тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах	3
3. Компанийн 2025 оны санхүүгийн жилийн цэвэр ашиг (алдагдал)-аас ногдол ашиг хуваарилахгүй тухай шийдвэр, түүний шалтгааныг танилцуулах	3
4. Хурал, хурлын дэг	3
5. Санал хураалт	4
Хавсралт I — Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар	5
Хавсралт II — Хурлаас гарах шийдвэрийн төсөл	6
Хавсралт III — Саналын хуудасны загвар	7
Хавсралт IV — Тооллогын комиссын танилцуулга	8

1. ТАНИЛЦУУЛГА

Компанийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмын холбогдох заалтуудыг баримтлал болгон ТУЗ нь Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (“Хурал”)-ыг 2026 оны 04-р сарын 28-ны өдрийн 10:00 цагт Монгол Улс, Улаанбаатар 14241, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпийн гудамж 19А, Шангри-Ла зочид буудал, 1-р давхар, Шанхай өрөөнд биечлэн хуралдуулж энэ Хурлын 2 дахь хэсэгт заасан асуудал буюу Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах бөгөөд Компанийн 2025 оны жилийн үйл ажиллагааны тайлан, 2025 оны санхүүгийн жилийн цэвэр ашиг (алдагдал)-аас ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн шийдвэр, түүний шалтгааныг танилцуулна.

2. 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ТУЗ-ИЙН ГАРГАСАН ДҮГНЭЛТИЙГ БАТЛАХ

Компанийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу ТУЗ нь Компанийн 2025 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, тайлангийн талаар ТУЗ-ийн дүгнэлтийг танилцуулан Хурлаар батлуулна. Тус асуудал нь Хурлаар хэлэлцэх 1 дэх асуудал бөгөөд тус асуудлыг хэлэлцэн Хурлаас гарах тогтоолын төслийг энэ Хурлын материалын Хавсралт II-с харна уу.

3. 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ЖИЛИЙН ЦЭВЭР АШИГ (АЛДАГДАЛ)-ААС НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХГҮЙ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу ТУЗ нь Компанийн 2025 оны санхүүгийн жилийн цэвэр ашиг (алдагдал)-аас ногдол ашиг хуваарилах эсэх талаар хэлэлцэн шийдвэрлэсэн бөгөөд тус шийдвэрийг Хуралд танилцуулна.

4. ХУРАЛ, ХУРЛЫН ДЭГ

Хурлыг 2026 оны 04-р сарын 28-ны өдрийн 10:00 цагт Монгол Улс, Улаанбаатар 14241, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпийн гудамж 19А, Шангри-Ла зочид буудал, 1-р давхар, Шанхай өрөөнд биечлэн хуралдуулна.

ТУЗ-өөс Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдрийг 2026 оны 04-р сарын 01-ний өдрөөр тогтоосон.

Хурлыг Гүйцэтгэх захирал Г.Чинзориг даргалж, Хурлын зохион байгуулалтыг Конвиниенс дэлгүүрийн бизнесийн Санхүүгийн газрын захирлаар удирдуулсан Хурал зохион байгуулах комисс дор дурдсан дэгийн дагуу хуралдуулна.

Хурал эхлэхийн өмнө Тооллогын комисс Хурлын ирцийг тоолж Хурлын даргад мэдэгдэнэ. Хурлын ирц бүрдсэнээр Хурлын дарга хурлыг нээж хурал хуралдуулах дэгийг танилцуулна.

Хурлаар хэлэлцүүлэх 1 дэх асуудал буюу Компанийн 2025 оны жилийн үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлан болон Компанийн 2025 оны санхүүгийн жилийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах асуудлыг Хурал зохион байгуулах комисс танилцуулна. Хувьцаа эзэмшигчид тус асуудалтай холбоотой асуулт асууж Компани холбогдох тодруулга, хариултыг өгнө.

Хуралд танилцуулах 1 дэх асуудал буюу Компанийн 2025 оны санхүүгийн жилийн цэвэр ашиг (алдагдал)-аас ногдол ашиг хуваарилах эсэх талаарх ТУЗ-ийн шийдвэрийг Хурал зохион

байгуулах комисс танилцуулна. Хувьцаа эзэмшигчид тус асуудалтай холбоотой асуулт асууж Компани холбогдох тодруулга, хариултыг өгнө.

Хурлаар хэлэлцүүлэх өөр асуудал байхгүй тул Хувьцаа эзэмшигчдээс нэмэлт асуулт байхгүй тохиолдолд Хурал зохион байгуулах комисс санал хураалтыг эхлүүлнэ. Санал хураалт 10 минут үргэлжилнэ. Тооллогын комисс саналыг тоолж, санал хураалтын дүнг нэгтгэн танилцуулна. Хуралд оролцогчид санал хураалтын үр дүнтэй танилцсаны дараа Хурлын дарга Хурлаас гарах тогтоолыг танилцуулаад Хурлыг хаана.

Хурлын зарыг энэ Хурлын материалын Хавсралт I, Хурлаас гарах шийдвэрийн төслийг Хавсралт II-с тус тус харна уу.

5. САНАЛ ХУРААЛТ

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигч хувь хүнийн хувьд иргэний үнэмлэх, байгууллага бол байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ болон байгууллагын итгэмжлэлийг үзүүлсний үндсэн дээр Хуралд оролцох бүртгэл ээ баталгаажуулна.

Санал хураалтыг урьдчилан болон Хурлын санал хураалтын үеэр саналын хуудсаар бичгээр авна.

Хувьцаа эзэмшигч өөр хүнээр төлөөлүүлэн санал өгөх бол тухайн төлөөлөх хүнд итгэмжлэл олгож нотариатаар баталгаажуулсан байх ба уг итгэмжлэл нь зөвхөн тухайн Хурлын санал хураалтад хүчинтэй байна.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигч нь Хурлаар хэлэлцэх асуудалд “Зөвшөөрсөн”, “Татгалзсан” эсвэл “Түдгэлзсэн” болохоо илэрхийлж харгалзах нэг нүдэнд ☒ тэмдэглэгээг хийж саналаа өгнө. Компанийн гаргасан энгийн нэг хувьцаа нэг саналын эрхтэй тэнцүү байна.

Хурлын санал хураалтыг Тооллогын комисс удирдан зохион байгуулна. Тооллогын комиссын танилцуулгыг энэ Хурлын материалын Хавсралт IV, Саналын хуудасны загварыг Хавсралт II-с тус тус харна уу.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ЗАР

Премиум Нэксус ХК (“Компани”)-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”)-ийн 2026 оны 03-р сарын 13-ны өдрийн 5 тоот тогтоолоор хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (“Хурал”)-ыг 2026 оны 04-р сарын 28-ны өдрийн 10:00 цагт Монгол Улс, Улаанбаатар 14241, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпийн гудамж 19А, Шангри-Ла зочид буудал, 1-р давхар, Шанхай өрөөнд биечлэн хуралдуулна.

Хурлаар дараах асуудлыг хэлэлцэн батална. Үүнд:

1. Компанийн 2025 оны жилийн үйл ажиллагааны тайланг танилцуулах;
2. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах;
3. Компанийн 2025 оны санхүүгийн жилийн цэвэр ашиг (алдагдал)-аас ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн шийдвэр, түүний шалтгааныг танилцуулах.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдөр нь 2026 оны 04-р сарын 01-ний өдөр байна. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчид нь Компанийн www.cumongol.mn вэбсайтаас, эсвэл 2026 оны 04-р сарын 01-ний өдрөөс 04-р сарын 27-ны өдрийн (ажлын өдрүүдэд) 16:00–18:00 цагийн хооронд Монгол Улс, Улаанбаатар 13312, Баянзүрх дүүрэг, 26-р хороо, Олимп хороолол, Их Монгол Улсын гудамж 202, Сакура Тауэр, 7-н давхарт хүрэлцэн ирж Хурал хуралдуулахтай холбоотой баримт бичигтэй танилцах боломжтой.

Хурал зохион байгуулах комиссын даргаар Конвиниенс дэлгүүрийн бизнесийн Санхүүгийн газрын захирал Д.Бүдханд, Маркетингийн газрын захирал М.Отгонтунгалаг, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Т.Гантулга нар ажиллах бөгөөд Хуралд оролцож, санал өгөхтэй холбоотой мэдээллийг 2026 оны 04-р сарын 01-ний өдрөөс 04-р сарын 27-ны өдрийн (ажлын өдрүүдэд) 16:00–18:00 цагийн хооронд 8610-6181 утсаар эсвэл gantulga.t@cumongol.mn цахим шуудангаар авах боломжтой.

**ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 1: КОМПАНИЙН 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТАЛААРХ ДҮГНЭЛТИЙГ БАТЛАХ**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх заалт, Премиум Нэксус ХК (“Компани”)-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны 04-р сарын 28-ны өдрийн ээлжит хурал (“Хурал”)-ын шийдвэр, Хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн 2025 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хавсралт ёсоор баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН САНАЛЫН ХУУДАС

Хувь хүний овог, нэр/Байгууллагын оноосон нэр: _____

Регистрийн дугаар: _____

Эзэмшиж буй энгийн хувьцааны тоо: _____

Премиум Нэксус ХК (“Компани”)-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (“Хурал”)-д оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг 2026 оны 04-р сарын 01-ний өдрөөс эхлэн 2026 оны 04-р сарын 27-ны өдөр хүртэл эсвэл Хурлын үеэр хүлээн авна.

Хувьцаа эзэмшигчид 2026 оны 04-р сарын 28-ны өдрийн 10:00 цагт Монгол Улс, Улаанбаатар 14241, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпийн гудамж 19А, Шангри-Ла зочид буудал, 1-р давхар, Шанхай өрөөнд биечлэн ирж бичгээр санал өгнө.

Хувьцаа эзэмшигч өөр хүнээр төлөөлүүлэн санал өгөх бол тухайн төлөөлөх хүнд итгэмжлэл олгож нотариатаар баталгаажуулсан байх ба уг итгэмжлэл нь зөвхөн тухайн Хурлын санал хураалтад хүчинтэй байна.

ХУРЛААС ГАРАХ ШИЙДВЭРИЙН ТӨСӨЛ	ЗӨВШӨӨРСӨН (Санамж 1)	ТАТГАЛЗСАН (Санамж 1)	ТҮДГЭЛЗСЭН (Санамж 1)
Компанийн 2025 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хавсралт ёсоор баталсугай.			
<u>Санамж 1:</u> “Зөвшөөрсөн”, “Татгалзсан” эсвэл “Түдгэлзсэн” ээ илэрхийлж харгалзах нэг нүдэнд ☒ тэмдэглэгээг хийж санал аа өгнө.			

Хувьцаа эзэмшигчийн баталгаажуулалт:

Огноо:

ТООЛЛОГЫН КОМИССЫН ТАНИЛЦУУЛГА

Хурлын Тооллогын комиссоор Голомт Капитал ҮЦК ХХК ажиллана. Голомт Капитал ҮЦК ХХК нь Санхүүгийн зохицуулах хорооноос брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөлтэй, тус салбарт 2012 оноос үйл ажиллагаа явуулж буй туршлагатай компаниудын нэг юм.

Тооллогын комисс нь хурлын ирцийг тогтоож, хурлын даргад мэдээлэх, хурлаар хэлэлцэх асуудал тус бүрээр хурлын ирц болон саналын эрхтэй байх хувьцааны тоо, төрлийг тодорхойлох, санал өгөх журмыг тайлбарлах, санал тоолж, санал хураалтын дүнг нэгтгэж, дүнгийн тухай хуралд танилцуулах, хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, санал өгөх эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан гарах асуудалд тайлбар өгөх болон хуульд заасан бусад эрх үүрэгтэйгээр Хуралд оролцоно.

Тооллогын комиссын бүрэлдэхүүнээр дараах хүмүүс ажиллана. Үүнд:

1. Голомт Капитал ҮЦК ХХК-ийн Шинжээч Г.Эрдэнэбаясгалан (дарга) (8527-2507);
2. Голомт Капитал ҮЦК ХХК-ийн Брокер А.Чинзориг (8011-9258);
3. Голомт Капитал ҮЦК ХХК-ийн Брокер Т.Алтангэрэл (8075-8889).